Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны төсвийн нийт зардлын 1,782,031.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 17,820.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,139,742.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 21,397.4 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 17,117.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг заасныг зөрчин Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж цалин тооцоолох хүснэгтийн цалингийн зөрүү хэсэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр нягтлан бодогч нь өөртөө 3,000.0 мянга, бага ангийн багшид 500.0 мянга, орос хэлний багшид 500.0 мянга, монгол хэлний багшид 680.0 мянга, нийт 4,680.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцоолон олгосон, 2025 оны 8, 9 дүгээр саруудад нягтлан бодогч нь өөрөө ээлжийн амралттай байх хугацаанд ээлжийн амралтын цалин дээр 3,905.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан авсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант онд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,666,480.0 мянган төгрөгийн 53 гүйлгээг, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 157,192.5 мянган төгрөгийн 20 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 37 шийдвэрийг хугацаа хоцроож, байгууллагын батлагдсан төсвийг байршуулаагүй зөрчилд зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж цалин тооцоолох хүснэгтийн цалингийн зөрүү хэсэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр нягтлан бодогч нь өөртөө 3,000.0 мянга, бага ангийн багшид 500.0 мянга, орос хэлний багшид 500.0 мянга, монгол хэлний багшид 680.0 мянга, нийт 4,680.0 мянган төгрөгийн цалинг илүү тооцоолон олгосон, 2025 оны 07 сарын цалин хөлс тооцоолон олгохдоо математикийн багшаас 500.0 мянган төгрөгийн суутгалыг илүү суутгасан, 2025 оны 8, 9 дүгээр саруудад нягтлан бодогч нь өөрөө ээлжийн амралттай байх хугацаанд ээлжийн амралтын цалин дээр 3,905.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан авч албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэж заасны дагуу сахилгын шийтгэл тооцуулах албан шаардлага өгөх, гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй тул хууль хяналтын байгууллагад шалгуулахаар Монгол улсын Ерөнхий аудиторт хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цалин урамшууллын зардлыг анхаарах.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,832,757.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 9,085.1 мянган төгрөгийн 3 зөрчилд төлбөрийн акт тогтоож, илэрсэн алдаа зөрчилтэй холбоотойгоор 1 хариуцлага

тооцуулах албан шаардлага, шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 1,823,672.5 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт-1

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж цалин тооцоолох хүснэгтийн цалингийн зөрүү хэсэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө 3,000.0 мянга, бага ангийн багшид 500.0 мянга, орос хэлний багшид 500.0 мянга, монгол хэлний багшид 680.0 мянга, нийт 4,680.0 мянган төгрөгийн цалин илүү тооцоолон олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх” Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад “Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах” гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад “Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно”, 7.1.6 дахь заалтад “Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх” 15.1 дэх хэсэгт Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно”, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон 4,680.0 мянган төгрөгийн цалинг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Төлбөрийн акт-2

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын нь цалинг тооцоолон 2025 оны 07 сарын цалинг тооцоолон олгохдоо математикийн багшаас 500.0 мянган төгрөгийн суутгалыг илүү суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү суутгасан 500.0 мянган төгрөгийг тухайн албан хаагчид нөхөн олгохоор төлбөрийн акт тогтоолоо.

Төлбөрийн акт-3

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж 2025 оны 8, 9 дүгээр саруудад ээлжийн амралтын цалин дээр 3,905.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан авсан байна.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж цалин тооцоолох хүснэгтийн цалингийн зөрүү хэсэгт ямар нэгэн шийдвэргүйгээр өөртөө 3,000.0 мянга, бага ангийн багшид 500.0 мянга, орос хэлний багшид 500.0 мянга, монгол хэлний багшид 680.0 мянга, нийт 4,680.0 мянган төгрөгийн цалин хөлс илүү тооцоолон олгосон, 2025 оны 07 сарын цалин хөлс тооцоолон олгохдоо математикийн багш Б.Мөнхцэцэгээс 500.0 мянган төгрөгийн суутгалыг илүү тооцоолон суутгасан, 2025 оны 8, 9 дүгээр саруудад өөрийн ээлжийн амралттай өдрүүдэд 30 өдрийн цалинг давхардуулан тооцож 3,905.1 мянган төгрөгийг илүү авч албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн байна.	1							1	1		
Дүн	4	9,085.1	3	9,085.1				1	1		

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль тайлант онд Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,666,480.0 мянган төгрөгийн 53 гүйлгээг, Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 157,192.5 мянган	1	1,823,672.5					1	1,823,672.5

төгрөгийн 20 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулах 37 шийдвэрийг хугацаа хоцроож, байгууллагын батлагдсан төсвийг байршуулаагүй байна								
Дүн	1	1,823,672.5					1	1,823,672.5
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1	1,823,672.5					1	1,823,672.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



М.БАТСУУРЬ/

/М.БАТ-АМГАЛАН/

Д.АМАРМЭНД/

2026 оны 02 сарын 25-ны өдөр

байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг”, 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад “Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно”, 7.1.3 дахь заалтад “Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах”, 7.1.6 дахь заалтад “Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад “Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх” 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/18/А-2070413

Улаангом

УБА - 2026 1174/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Увс аймгийн Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж цалин тооцоолох хүснэгтийн цалингийн зөрүү хэсэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө 3,000,000 төгрөг, бага ангийн багшид 500,000 төгрөг, орос хэлний багшид 500,000 төгрөг, монгол хэлний багшид 680,000 төгрөг, нийт 4,680,000 төгрөгийн цалин илүү тооцоолон олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх" Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад "Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг", 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад "Энэ хуулийн 4.1-д заасан этгээдэд бусад хууль тогтоомжид тусгайлан хориглосноос гадна авлигын дараах зөрчлийг хориглоно", 7.1.3 дахь заалтад "Албан үүргээ гүйцэтгэхдээ хууль бусаар аливаа хувь хүн, хуулийн этгээдэд давуу байдал олгох, олгохоор амлах, бусдын эрхийг хязгаарлах", 7.1.6 дахь заалтад "Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх" 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх заалтад "Хуулиар зөвшөөрөөгүй бусад" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий

аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон цалин 4,680,000 /Дөрвөн сая зургаан зуун наян мянга/ төгрөгийг Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Б.Лхамсүрэнээр төлүүлж Мэргэжлийн хяналтын газрын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Цэрэннадмид, нягтлан бодогч Б.Лхамсүрэн нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.АМАРМЭНД

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ





УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/19/Б.2070412
УБА-2026/174/НА-СТА-ТЦЗ

Улаангом

Нөхөн олгох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Увс аймгийн Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2025 оны 07 сарын цалинг тооцоолохдоо математикийн багшаас 500,000 мянган төгрөгийг илүү суутгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна” 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3-д “Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.3.3 дахь заалтад “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү суутгасан цалин 500,000 /таван зуун мянга/ төгрөгийг багш Б.Мөнхцэцэгт нөхөн олгох.
2. Актын биелэлтийг 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын

сургуулийн захирал Д.Цэрэннадмид, нягтлан бодогч Б.Лхамсүрэн нарт хариуцуулав.

3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР



Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР



М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/20/АД070413

Улаангом

УВА - 2026 /174/МА-СТА-ТНЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Увс аймгийн Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь албаны эрх мэдлээ ашиглаж 2025 оны 8, 9 дүгээр саруудад өөрөө ээлжийн амралттай байх хугацаанд ажилласнаар 3,905,084 төгрөгийн цалинг давхардуулан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх", Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад "Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг", 7.1.6 дахь заалтад "Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх", 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх заалтад "Хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5 дахь заалтад "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэгт "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудитормын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх,

төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3 дахь заалтад "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Дахардуулан олгосон цалин 3,739,325 /гурван сая долоон зуун гучин есөн мянга гурван зуун хорин тав/ төгрөгийг Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Б.Лхамсүрэнээр төлүүлж Мэргэжлийн хяналтын газрын орлогын 100150000982 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Цэрэннадмид, нягтлан бодогч Б.Лхамсүрэн нарт хариуцуулав.
3. Төлбөрийн актыг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТОР

Т.АМАРМЭНД

АУДИТЫН МЕНЕЖЕР

М.БАТ-АМГАЛАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ





УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 01/41/18070413
УВА-2026/174/НА-СТА-ТЦБ

Улаангом

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч нь 2024 онд Цагаанхайрхан сумын Соёлын төвд ажиллаагүй багшийн нэр дээр цалин гаргаж авсанд төлбөрийн акт тогтоож байсан, Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар албаны эрх мэдлээ ашиглаж цалин тооцоолох хүснэгтийн цалингийн зөрүү хэсэгт эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр өөртөө 3,000.0 мянга, бага ангийн багшид 500.0 мянга, орос хэлний багшид 500.0 мянга, монгол хэлний багшид 680.0 мянга, нийт 4,680.0 мянган төгрөгийн цалинг илүү олгосон, 2025 оны 07 дугаар сарын цалин олгохдоо математикийн багшаас 500.0 мянган төгрөгийг илүү суутгасан, 2025 оны 8, 9 дүгээр саруудад өөрийн ээлжийн амралтын цалин дээр 3,905.1 мянган төгрөгийн цалинг давхардуулан авсан, өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна", 16.5.5 дахь заалтад "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт "Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно", 39.1.2 дахь заалтад "Албаны эрх мэдлээ хэтрүүлэх" Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад "Албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах" гэж албан тушаалын эрх мэдлийг албаны эрх ашгийн эсрэг буюу хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийхийг", 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь заалтад "Албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах, хэтрүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.2.9 дэх заалтад "Энэ хуулийн үйлчлэлд хамаарах хуулийн этгээд, албан тушаалтан үйлдэл, эс үйлдэхүйн улмаас улсад учруулсан хохирол, зөрчлийн хариуцлагаа бүрэн хүлээдэг байх" 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт "Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно", 12.1.4 дэх заалтад "Хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5 дахь заалтад "Дансны

өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, 42.3-т “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ” гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Б.Лхамсүрэнд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2026 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Цагаанхайрхан сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Цэрэннадмидад даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.АМАРМЭНД

М.БАТ-АМГАЛАН

М.БАТСУУРЬ